ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН 2024 ОНЫ НЭГДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар сарын 16 Дугаар 03 Улаанбаатар хот

Журмуудын шинэчилсэн
найруулга батлах тухай

Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн 9.6.9 дахь заалтыг удирдлага болгож, тус хуралдааны хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 2024 оны 03 сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэдийн Оролцооны Нэгдэл Намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагааг зохицуулах журам (Шинэчилсэн найруулга)-ыг 1-р хавсралтаар баталсугай.
2. ИОН Намаас төрийн сонгуульд нэр дэвшихээ илэрхийлсэн гишүүдийн тандалт үнэлгээний тухай журам (Шинэчилсэн найруулга)-ыг 2-р хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ИОНН-ын Төлөөлөгчдийн Танхимын 2023 оны тавдугаар хурлын 02 дугаар тогтоол, зургаадугаар хурлын 02 дугаар тогтоол, тэдгээрийн хавсралтыг тус тус хүчингүйд тооцсугай.

ДАРГА Ц.ОЮУНГЭРЭЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ОТГОНЧИМЭГ

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ ҮНН 8499254 9022061071

ИОНН-ын Төлөөлөгчдийн Танхимын
2024 оны НЭГДҮГЭЭР хурлын
03-р тогтоолын 1-р хавсралт

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМААС ТӨРИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШҮҮЛЭХ, БОЛОВСОН ХҮЧНИЙГ ШИЛЖ СОНГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

(Шинэчилсэн найруулга)

Нэг. Төрийн сонгуульд ИОНН-ыг төлөөлж нэр дэвшүүлэх байгууллага

1.1. Намын дараах байгууллага ИОНН-ыг төлөөлж дараах сонгууль, албан тушаалд нэр дэвшүүлэх байгууллага байх бөгөөд нам улс төрийн сонгуульд оролцох тухай төрийн байгууллагад илэрхийлнэ. Үүнд:

1.1.1. УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд намаас нэр дэвшүүлэх байгууллага нь ИОНН-ын Төлөөлөгчдийн Танхим байна.

1.1.2. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлэх байгууллага нь нийслэлийн Танхим байна. Нийслэлийн танхим байгуулагдаагүй байгаа үед уг сонгууль болбол нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлэх байгууллага нь Танхим байгуулагдсан нэг дүүргийн танхим, эсвэл намын танхим бүхий дүүргүүдийн танхимын хамтарсан хурал байна.

1.1.3. Аймаг, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшүүлэх байгууллага нь тухайн аймаг дүүргийн танхим байна. Хэрэв аймаг, дүүрэгт танхим байгуулагдаагүй бол тухайн аймаг, дүүрэг дэх салбар байгуулагдсан нэг сум, хорооны танхим, эсвэл намын салбар бүхий сум, хороодын танхимын хамтарсан хурал байна.

1.1.4. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчдийн сонгуульд ИОНН-аас нэр дэвшүүлэх байгуулага нь тухайн сум, хорооны танхим байна.

1.2. Төрийн сонгуульт байгууллагад ИОНН олонхи болсон, эсвэл өөр нам, эвсэлтэй хамтран олонхийг бүрдүүлэх тохиолдолд дараах түвшний албан тушаалтныг намын дараах байгууллагаас санал болгож уламжилна. Үүнд:

1.2.1. Монгол улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигчийг Төлөөлөгчдийн танхим санал болгож УИХ дахь намын бүлэгт уламжилна.

1.2.2. Нийслэлийн ИТХ-ын дарга, нийслэлийн засаг даргад нэр дэвшигчийг Нийслэлийн танхим, нийслэлийн танхим байгуулагдаагүй бол дүүргүүдийн танхим хамтарсан хурлаараа тус тус санал болгож Нийслэлийн ИТХ дахь намын бүлэгт уламжилна.

1.2.3. Аймаг, дүүргийн ИТХ-ын дарга, аймаг, дүүргийн засаг даргад нэр дэвшигчийг тухайн аймаг, дүүргийн танхим, уг танхим байгуулагдаагүй бол салбартай сумдын танхим хамтарсан хурлаар тус тус санал болгож аймаг, дүүргийн ИТХ дахь намын бүлэгт уламжилна.

1.2.4. Сумын ИТХ-ын дарга, сумын засаг дарга, Хорооны засаг дарга, Хорооны ИНХ-ын тэргүүлэгчид нэр дэвшигчийг тухайн сум, хорооны танхим санал болгож сумын ИТХ дахь намын бүлэгт болон хорооны ИНХуралд тус тус уламжилна.

Хоёр. Намын гишүүн өөрийгөө илэрхийлэх

2.1. Энэ журмаар зохицуулагдаж буй аливаа нэр дэвшилтийг зөвхөн өөрийгөө илэрхийлсэн намын гишүүдийн хүрээнд авч хэлэлцэнэ.

2.2. Намын гишүүн Намын дүрмийн 17.2-т заасны дагуу дараах хугацаанд, дараах хэлбэрээр өөрийгөө илэрхийлсэн байна.

2.2.1. Улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний болзлыг сонгуулийн өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-нээс ээлжит сонгуулийн жил санал хураалт болох өдрөөс хоёр сарын өмнө, ээлжит бус болон нөхөн сонгуулийн үед намын Дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсгээс зарласан хугацаанд багтан хангаж Бүртгэгчид бүртгүүлэх;

2.2.2. Төрийн ээлжит сонгуулийн хооронд хамгийн багадаа нэг удаа хандивлагч гишүүнээр бүртгэгдсэн байх. Ээлжит бус, нөхөн сонгуулийн үед намын Дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсгээс зарласан хугацаанд багтан хандивлагч гишүүний болзлыг хангаж Бүртгэгчид бүртгүүлэх;

2.2.3. Намын мөрийн хөтөлбөрт нийцсэн идэвхтэй үйл ажиллагааг зохион байгуулах, манлайлах, нийгэмд танигдах;

2.2.4. Намын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож оролцооны оноо цуглуулах

2.2.5. Нэр дэвших шат шатныхаа түвшинд намын мөрийн хөтөлбөр боловсруулахад оролцох, эсвэл мөрийн хөтөлбөрт оруулах санал, хуулийн төсөл, бодлогын баримт бичгийг санаачилж тухайн шатны намын байгууллагын хуралд, эсхүл ИОНН-ын гишүүдийн аль нэг сургалтанд танилцуулсан, эсхүл хэлэлцүүлсэн байх.

Гурав. Сургалтад хамрагдах, тойргийн нэрсийн урьдчилсан жагсаалт

3.1. Энэхүү журмын 2.2.1-д заасны дагуу өөрийгөө илэрхийлсэн хуримтлал бүрдүүлэгч гишүүдийг намын тухайн сонгуульд нэр дэвшүүлэх эрх бүхий шатны ажлын албанаас тухайн сонгуульд зориулан зохион байгуулах сургалтанд урьж оролцуулна.

3.2. Энэ журмын 3.1-д дурдсан сургалтад орох урилгыг өөрийн бүртгэлтэй цахим хаягаар хүлээн авсан гишүүд сургалтанд биечлэн, эсхүл цахимаар оролцох, сургалтын материалыг ижил тэгш авах эрхтэй.

3.3. Сургалтын явцад хуримтлал бүрдүүлэгч гишүүн өрсөлдөх тойргоо бусад хуримтлал бүрдүүлэгч гишүүдийн өмнө нээлттэй сонгох, бусад гишүүдийн сонголтын талаар мэдээлэл авах, багаар ажиллах, тойргийн сонголтыг өөрчлөх, сонгосон тойрог дахь бусад хуримтлал бүрдүүлэгч гишүүн, намын салбар, танхимын бүрэлдэхүүний мэдээллийг авах болон сонгуулийн хууль тогтоомжийн дагуу бичиг баримт бүрдүүлэх, сонгуульд ИОН намаас нэр дэвших болзлыг хэрхэн хангах талаар зөвлөмж туслалцаа авах эрхтэй.

3.4. Энэ журмын 3.1-3.3 дахь заалтад дурдсан сургалтад оролцсон, эс оролцсоноос үл хамааран ИОНН-ын гишүүн нь Дотоод сонгуулийн төв ажлын хэсгээс зарласан хугацаанд багтаан төрийн сонгуульд ИОНН-аас нэр дэвших өргөдлөө тус ажлын хэсэгт бичгээр ирүүлэх бөгөөд Дотоод сонгуулийн төв ажлын хэсэг гишүүдээс өргөдөл хүлээж авах ажиллагааг хаасны дараа Сонгуулийн тухай хууль тогтоомж, ИОНН-ын дүрэм, журмын болзол шаардлага хангасан нэрсийн жагсаалтыг өргөдөл ирүүлсэн дараалын дагуу нэгтгэн гаргаж Тандалт үнэлгээний ажлын хэсэгт шилжүүлнэ.

3.5. Дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсэг нь энэ журмын 3.4-д заасан заасан болзлыг хангаагүй гишүүний хүсэлтийг ажлын нэг өдөрт багтаан буцаана.

Дөрөв. Тандалт үнэлгээ

4.1. Төрийн сонгуульд намаас нэр дэвшигчийн тандалт үнэлгээг ИОН Намаас төрийн сонгуульд нэр дэвшихээ илэрхийлсэн гишүүдийн тандалт үнэлгээний тухай журмын 1.2.1-1.2.4-т заасан тушаалаар байгуулагдах Тандалт үнэлгээний ажлын хэсэг зохион байгуулна.

4.2. Тандалт үнэлгээний ажлын хэсэг нь энэ журмын 4.1-д дурдсан тушаал болон тухайн шатны салбарын даргын тушаалд заасан хугацаанд багтаан, дараахь үйл ажиллагааг зөвхөн Дотоод сонгуулийн төв ажлын хэсгээс ирүүлсэн нэрсийн жагсаалтад үндэслэн зохион байгуулна.

4.3. Тандалт үнэлгээний ажлын хэсэг нь "ИОН намаас төрийн сонгуульд нэр дэвшихээ илэрхийлсэн гишүүдийн тандалт үнэлгээний тухай журам"-ын дагуу үнэлгээ хийж, эрэмбийг гаргана.

4.4. Энэхүү тандалт, үнэлгээг үнэн зөв зохион байгуулахад шаардлагатай төсвийг Тандалт үнэлгээний ажлын хэсгээс төлөвлөж намын Ерөнхий менежерт хүргүүлнэ.

4.5. Тандалт, үнэлгээний ажлын хэсэг нь гаргасан эрэмбэ, дүгнэлтээ төрийн сонгуульд ИОНН-ыг төлөөлж нэр дэвшүүлэх тухайн шатны намын удирдлагад

хаяглан илгээх ба хувийг тандалт, үнэлгээнд нэр нь хамрагдсан гишүүнд тухайн сонгуулийн нэр дэвшилтийг шийдэх хурлаас 2-3 хоногийн өмнө явуулсан байна.

Тав. Намын байгууллага шийдвэр гаргах

5.1. Төрийн сонгуульд ИОНН-ыг төлөөлж нэр дэвшүүлэх байгууллагад аливаа нэр дэвшигчийн асуудлыг хурлаар оруулж хэлэлцүүлэхийн өмнө тухайн шатны намын удирдлага Дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсгээс гаргасан нэр дэвшигчдийн жагсаалт, түүнийг Тандалт үнэлгээний ажлын хэсгээс эрэмбэлсэн жагсаалтыг тус тус хүлээн авч, тэдгээртэй нийцүүлсэн хуралд оруулах нэр дэвшигчдийн жагсаалтыг бэлтгэнэ.

5.2. Энэ журмын 5.1-д заасан хуралд оруулах нэр дэвшигчдийн жагсаалтыг бэлтгэхдээ Намын зохих шатны удирдлага дараах зүйлийг харгалзана. Үүнд:

5.2.1. Тандалт үнэлгээний эрэмбэ алдагдахгүй байх;

5.2.2. Тойрогт нэр дэвшигчдийн тоо тойргийн нийт мандатын 50 хувиас илүү болсон тохиолдолд намын жагсаалтад нэр дэвших эсэхээр гишүүдийн саналыг ерөнхий эрэмбийн дагуу асууж, жагсаалтын болон тойргийн нэр дэвшилтийг бүрдүүлэх;

5.2.3. Нэг хүн нэг тойрогт дэвших, тойрог ба жагсаалтад нэг хүнийг давхар дэвшүүлэхгүй байх зарчмыг баримтлах;

5.2.4. Хуулинд заасан жендерийн харьцааг хангах;

5.2.5. Нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзах;

5.2.5. Сонгуулийн тухай хууль, ИОНН-ын дүрэм журманд заасан нэр дэвшигчийн нийтлэг болон нэмэлт шаардлагыг хангасан бүрэлдэхүүн байх;

5.2.5. Сонгуульд эвсэл болж орсон тохиолдолд Эвслийн гэрээтэй нийцүүлэх.

5.3. Төрийн сонгуульд ИОНН-ыг төлөөлж нэр дэвшүүлэх хурлаар тухайн шатны хуралд оруулж буй нэр дэвшигчдийн жагсаалтыг хэрхэн үйлдсэн тухай намын удирдлагын танилцуулга, нэр дэвшигч нэг бүрийн талаар тандалт үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус сонссоны дараа нэр дэвшихээр бүртгэгдсэн гишүүдээс асуух асуултыг бүртгэж авна.

5.4. Энэ журмын 5.3-д заасны дагуу бүх асуултыг нэгмөсөн сонссоны дараа нэр дэвшигч бүр хурал даргалагчийн зарласан ижил хугацаанд багтаан өөрт хамааралтай, эсвэл өөрийн сонгосон асуултад хариулна.

5.5. Энэ журмын 5.3- 5.4 дахь ажиллагаа явагдаж дуусаны дараа хуралд оруулах нэр дэвшигчдийн жагсаалтын дагуу нууц санал хураалтыг зохион байгуулж, эрх бүхий байгууллагын хуралд оролцсон гишүүдээс хамгийн олон хүний санал авсан нэр дэвшигчийг намын нэр дэвшигчээр батална.

5.6. Хэрэв нэр дэвшигчдийг багаар нь дэмжихээр хуралд оролцсон гишүүдийн олонхи нууцаар санал өгсөн бол саналын хуудсанд бичигдсэн нийт нэр дэвшигчдийг намын нэр дэвшигчээр баталгаа.

5.6. Энэ журмын 5.5-д заасан санал хураалт дуусаны дараа хуралд оруулах нэр дэвшигчдийн сонгоогүй сул орон тоонд нэр дэвшүүлэлтийг намын эрх бүхий байгууллагын хурал дээр зохион байгуулж болно. Ингэхдээ Сонгуулийн тухай хуульд заасан жендерийн тэгш байдлын шаардлагыг хангасан сул орон тоог хурлын дарга зарлаж, сул орон тоонд нэрээ дэвшүүлэх эсэхийг хуралд санал таслах болон ажиглах эрхэйгээр оролцож буй гишүүдээс асууна.

5.7. Энэ журмын 5.5-т заасны дагуу сул орон тоонд хурал дээр нэрээ дэвшүүлэх гишүүн сонгуулийн хууль, ИОНН-ын дүрмэнд заасан нэр дэвшигчийн шаардлагыг хангаж байгаагаа нотолсон баримтуудыг хуралд танилцуулсны дараа нэр дэвшигчийг дэмжих эсэхээр нууц санал хураалт явуулж хамгийн олон санал авсан гишүүнийг нэр дэвшигчээр баталгаа. Хэрэв тус орон тоонд мандатын тооноос олон хүн нэр дэвшиж өрсөлдвөл саналын хуудсыг нэр дэвшсэн дараалын дагуу бэлтгэнэ.

Зургаа. Журам хүчин төгөлдөр болох

Энэхүү журам нь 2024 оны 3 дугаар сарын 17-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.